

Сэрээлт

Энэрэл нигүүлсэхүй нь энгийн хүний нийгэмд нинжин сэтгэл, хайраар илэрдэг бөгөөд энэ чанар Дафа-гийн шавь нарын сэтгэлийн гүнээс үргэлж гарч байх ёстой. Би сүүлийн үед нэг зүйлийн талаар бодож байна, би та нарыг амь бодийг аврахад тусал гэж уриалахад та нар ихэвчлэн үнэнийг хүмүүст таниулж эсвэл "Шэнь Юнь" тоглолтод тусалж хүмүүсийг аврах талаар боддог, зөвхөн үүгээр хязгаарлагдаж болохгүй. Харин өдөр тутмын ажлын орчиндоо болоод хаана ч байсан та нар хүн аврах сэтгэлийг тээж энэ зорилгоо ухамсарлаж явах ёстой, энэ нь нэн ялангуяа төрөл бүрийн хэвлэл мэдээллийн салбарт ажилладаг хүмүүсийн хувьд хамаатай. Сүнслэг амьдралын замаар яваа хүнд байвал зохих энэрэнгүй сэтгэлийг бусад хүмүүс мэдэрч ч чадахгүй байх тохиолдлууд байдаг. Та нарын зан байдлаас бясалгагчийн нинжин сэтгэлийг хүмүүс олж харахгүй байна. Тухайлбал, бид аливаа зүйлд санал бодлоо илэрхийлэхдээ хувийн үзэл баримтлалаа үндсэн шалгуур болгон ашиглаж болохгүй. Та нар энд амь бодийг сүнслэг оршихуйн түвшинд аврахад туслахаар ирсэн, мөн аливааг Жэнь, Шань, Рэнь - Үнэн, Нинжин, Тэвчээр дагуу цэгнэх ёстой. Наад зах нь та нарын бичиж, хэлж байгаа зүйлс эцэст нь хүмүүсийг аврагдахад нь нөлөө болохуйц байх ёстой.

Хамгийн ноцтой нь та нарын зарим нь улс төрийн өндөр албаны хүмүүс рүү хувийн дайралт хийдэг. Бид энд хүмүүст сүнслэг замаар дээшлэхэд нь, аюулаас ангижрахад нь туслахаар ирсэн, дайсан болохоор ирээгүй. Үнэнийг хэлэхэд, хэчнээн муу хүн байсан ч (ХКН-ын дарангуйлагч асан Жиан хорлонт чөтгөрийг эс тооцвол) хэн нэгэн рүү хувийн дайралт хийж болохгүй, ялангуяа АНУ-ын хоёр том улс төрийн намын чухал зүтгэлтнүүд рүү болохгүй. Хүн бүр энэ Фа-гийн төлөө энд ирсэн, бүгд авралыг хүлээж байна. Хувь хүн рүү дайрах нь амархан үзэн ядалт, дайсагналд хүргэх талтай байдаг. Үзэн ядалт нэгэнт үүсчихвэл түүнийг арилгахад хэцүү байдаг, тэгвэл бид хүмүүсийг яаж аврах юм? Энэ нь мөн хариу арга хэмжээ авахад хүргэдэг. Бид энэ талаар хангалттай сургамж аваагүй гэж үү? Бидний ихэнх нь гаднын хүмүүс, энэ нийгэмд байр

суурьгүй, тэр бүү хэл бид ХКН-ын хавчлагад хэлмэгдсэн дүрвэгсэд. Тиймээс биднийг гар сунган хүлээж авсанд АНУ-д талархах ёстой.

Бид юу ч бичсэн, юу ч хэлсэн хүмүүсийг аврахаас, хүмүүсийг хайрлахаас эхлэх ёстой. Зөвхөн хэвлэл мэдээллийнхэн гэлтгүй Дафа-гийн шавь бүр Дафа-д бясалгагчийн хийх ёстой зүйлийг хийж байгаа эсэхийг өөрөөсөө асууж байх ёстой. Та нарын хийснийг эргэж харахад санаа зовохгүй байх аргагүй байна. Олон хүн удаан хугацаанд бясалгалдаа хойргошиж, энгийн хүмүүс шиг зүйл хийдэг болсон нь Дафа-гийн шавийн төлөв байдал мөн үү? Та нар энэ асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Бидний олон хүн янз бүрийн хэвлэл мэдээллийн ажил хийдэг бөгөөд энэ нь үнэнийг хэлэх, хүмүүсийг аврахтай холбоотой байх ёстой. Та нарын зорилго зөвхөн товчлуур дарсан хүний тоог нэмэгдүүлэхийн төлөө гэж үү? Энэ нь Дафа-гийн шавь нарт байх ёстой төлөв мөн үү? Та нар энэ эцсийн өдрүүдэд хүмүүсийг аврахад үлдсэн бага хугацаагаа их дэмий үрж байна! Та нар хэзээ нэгэн цагт харамсах болно! Дафа-гийн шавь нарын үүрэг бол хүмүүсийг аврах явдал юм, гэхдээ та нар энэ хэвээр байвал энэрэнгүй сэтгэлээ алдах болно! Тэгвэл бясалгадаг хүний хэв шинж хэвээр байх уу? Зарим тохиолдсон зүйлийн талаар бодоод үз, тэдгээрийг хамааралгүй гэж үзэж болох уу? Дафа-гийн шавь нарыг Бурхад хамгаалдаг. Хэрэв асуудал гарвал энэ нь Бурхдын анхааруулга биш гэж үү? Та нар яагаад үүнээс санаа авахгүй байна вэ? Хэрэв үнэхээр том асуудал гарвал энэ нь бурхнаас ирсэн шийтгэл биш гэж үү? Хэрэв бид энэрэнгүй нинжин сэтгэлээ алдвал, үүрэг хариуцлага, эрхэм зорилгоо умартаж, тэр ч байтугай бясалгагч гэдгээ мартвал бид жирийн хүмүүс шиг болох нь гарцаагүй. Хэрэв Дафа-гийн шавь нар болон энгийн хүмүүсийн хоорондын ялгаа бүдгэрвэл та нарыг ямар бүлэг хүмүүс гэх вэ? Энэ аймшигтай биш гэж үү? Гэсэн хэдий ч бид нар орчлон ертөнцийн хамгийн агуу үүрэг хариуцлагыг үүрч буй амь бодиуд юм шүү!

Та нар Дафа-гийн шавь нарын хувьд улс төрд оролцох ёсгүй, улс төрийн намуудын өрсөлдөөнд оролцох ёсгүй гэж би үргэлж хэлдэг. Ардчилсан нам ч бай, Бүгд найрамдах нам ч бай энэ бол хүний асуудал. Хувь хүн бүр бурхдын аврахыг зорьсон амь бодиуд юм. Та

нар зөвхөн энэ намын талын хүмүүсийг аварна, нөгөөг нь аврахгүй гэж хэлж болохгүй. Тэд бүгд миний хүмүүс! Би болон Бурхад тэднийг аврахын төлөө байна! Хэрэв хэн нэгэн аврагдахыг хүсэхгүй бол энэ нь мэдээж өөр хэрэг. Дафа-гийн шавь нарын хувьд та нар хүмүүсийг шилж, сонгож болохгүй. Хүн бүр бурханлаг мөн чанартай бөгөөд хүн бүр Дафа-г олж авч аврагдахын тулд энэ дэлхийд ирсэн.

Түүнчлэн, та нар [хэвлэл мэдээллийн хэрэгслээр] аливаа зүйлийн талаар сэтгэгдлээ бичихдээ тухайн зүйлийн сайн муу талыг л ярилцах ёстой, хувь хүн дээр авч ярихгүй байх хэрэгтэй. Зарим хүн нэг талаар буруу зүйл хийж байж болох ч магадгүй бусад тал дээр сайн байж болно. Зарим хүмүүсийн үзэл бодол өөр өөр байж болох ч тэд муу хүмүүс гэсэн үг биш юм. Хэн бүхэнд энэрэнгүй хандаж, хүн бүрийг хайрлаж чадах нь жирийн хүмүүсийн хийж чадах зүйл биш. Ялангуяа бүгдэд энэрэнгүй сэтгэлээр хандаж бүхнийг хийх нь бүр ч хэцүү. Гэхдээ Дафа-гийн шавь нар заавал тийм байж чадах ёстой! Бясалгал бол үйл явц, шинэ сурагчид одоо үүнийг хийж чадахгүй ч бясалгалын явцад аажмаар хийж чаддаг болох ёстой. Хуучин сурагчид үүнийг 'одоо' хийж чаддаг байх ёстой. Энэ нь та нарт хүлээлгэсэн түүхэн үүрэг бөгөөд Дафа-гийн ариун шавь бүрийн бясалгалынхаа явцад хүрэх ёстой зүйл!

Багш Ли Хонжи 2024 оны 6-р сарын 6